

**УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИГЧ ВАЛЯ ОВОГТОЙ ТУНГАЛАГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Уриа: Шударга ёсыг хамтдаа бүтээцгээе**

1. Шударга зарчмыг баримтлан, Уламжлалт ёс заншлаа дээдэлж, ёс зүйн өндөр хэмжээг баримтлан ажиллана.
2. Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн ололтод тулгуурласан хөгжлийн бодлогыг дэмжинэ..
3. Эрүүл мэнд боловсрол, соёлын салбарын эрс шинэчлэлийг дэмжинэ.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах амьдрах, тааламжтай аюулгүй "ногоон" хот суурин газрын төлөвлөлтийг дэмжинэ.
5. Хүний эрхийг зөрчсөн, хүүхдийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгт холбогдуулах эрх зүйн хариуцлагыг чангатгах талаар хамтран ажиллана.
6. Өндөр настан болон ахмад иргэдэд зориулж тэтгэврийн дараах ажлын байрыг нэмэгдүүлэх тал дээр хамтран ажиллах
7. Мэргэшсэн төрийн албан хаагчдын үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах замаар ажлын байрнаас хууль бусаар халдаг байдлыг таслан зогсоох эрх зүйн шинэчлэлийг дэмжинэ.
8. Байгалийн баялагийн үр өгөөжийг ард түмэнд тэгш хувиарлах бодлогыг дэмжинэ.
9. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар чинээлэг дундаж давхаргыг бий болгохыг дэмжинэ.
10. Ухаалаг мал аж ахуй, газар тариалангийн салбарын шинэчлэх бодлогыг дэмжинэ.
11. Олборлох үйлдвэрлэл, бичил уурхайг эрхлэгчдийн үйлдлийн улмаас хууль бусаар хөндөгдсөн газрыг нөхөн сэргээх эрх зүйн орчныг шинэчлэх санаачлага гаргана.
12. Улсын төсвийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах (тендер) үйл ажиллагааг ард иргэдийн хяналтын дор шударга нээлттэй байхад хяналт тавьж ажиллана.
13. Орон нутгаа хөгжүүлэх ард иргэдээ дэмжих зорилготой "Баялагийн сан" байгуулахыг дэмжиж ажиллана.

НЭР ДЭВШИГЧ: *М.Тунгаг* В.ТУНГАЛАГ